



ИНД 137

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

**ХӨДӨӨ АЖ АХУЙН АГААРЫН ХӨЛГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Иргэний нисэхийн ерөнхий газар

Гарчиг

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
137.1. Зорилго	3
137.3. Ерөнхий шаардлага.....	3
137.5. Осол, зөрчлийн талаар мэдээлэх.....	3
Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖИЛТ	3
137.51. Өргөдөл гаргах Зорилго	3
137.53. Гэрчилгээ олгоход тавигдах шаардлага	3
137.55. Гэрчилгээний хугацаа	4
137.57. Гэрчилгээний хугацааг сунгах	4
137.59. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх	4
В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА	4
137.101. Бүртгэл тэмдэглэлд тавигдах шаардлага	4
137.103. Үндсэн бус баазаас нислэг үйлдэх	5
137.105. Хүн ам шигүү суурьшсан нутаг дэвсгэр дээгүүрх нислэг	5
137.107. Боловсон хүчний хангалт	5
137.109. Үйл ажиллагааны өөрчлөлт	5
137.111. Аюулгүй ажиллагааны хяналт шалгалт	5
Г БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЖУРАМ	5
137.151. Химийн бодис цацах.....	6
137.153. Аэродром дээрх эргэлтийн чиглэл	6
137.155. Аэродром дээрх эргэлтийн өндөр	6
137.157. Навигацийн гэрэлгүй үйлдэх нислэг	6
137.159. Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүр нислэг үйлдэх.....	6
137.161. Хүн ам шигүү суурьшсанаас бусад газар нутаг дээгүүр нислэг үйлдэх.....	6

137.163. Түлшний нөөцийг тооцох.....	7
Д БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ТУСГАЙ ЖУРАМ.....	7
137.201. Үйлчлэх хүрээ.....	7
137.205. Хөөрөлтийн зай ба нислэгийн зам (Гуравдагч талын эрсдэлгүй)7	
137.207. Хөөрөлтийн зай (Гуравдагч талын эрсдэлтэй).....	7
137.209. Хөөрөлтийн нислэгийн зам (Гуравдагч талын эрсдэлтэй)	7
Е БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БА ТОНОГЛОЛ.....	8
137.251. Ерөнхий зүйл	8
137.253. Суудал ба бэхэлгээ.....	8
137.255. Нэмэлт хэрэглэл	8
137.257. Нэмэлт тоноглол	8
ХАВСРАЛТ А. ГУРАВДАГЧ ТАЛЫН ЭРСДЭЛ.....	9
ХАВСРАЛТ Б. ЖИНГИЙН ХЭТРЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ	9
ХАВСРАЛТ В. ХЭРЭГЛЭЛ ТОНОГЛОЛЫН НТЧ.....	10
Хийцийн стандарт.....	10
В.1 Суудал болон бэхэлгээ	10
В.2 Бункерийн зөвшөөрөгдсөн хамгийн их ачаалал	10
В.3 Бункер болон шүршигч сав	10
В.4 Бункерийн багтаамжийн дээд түвшин.....	10
В.5 Аваарын цацагч тоноглол.....	11
В.6 Тэмдэг, тэмдэглэгээ.....	11
В.6.1. Ерөнхий зүйл	11
В.6.2.Бункер болон шүршигч савны хамгийн их ачаалал.....	11
В.6.3. Аваарын цацагч тоноглолын цацах хугацаа	11
В.6.4. Зорчигчийн байрлал.....	11
В.6.5. Нислэгийн хязгаарлалтууд	12

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

137.1 Зорилго

Энэхүү Бүлэгт

- (1) Хөдөө аж ахуй /цаашид ХАА гэх/-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй эсхүл дадлага хийж буй нисгэгчид зориулсан дүрмийн 91 дүгээр хэсэгт буй ерөнхий үйл ажиллагаа, нислэгийн дүрмүүдийн нэмэлт,
- (2) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй эсхүл дадлага хийж буй нисгэгчид зориулсан дүрмийн 91 дүгээр хэсэгт буй ерөнхий үйл ажиллагаа, нислэгийн дүрмүүдээс гадуур заалтууд,
- (3) Арилжааны ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчид гэрчилгээ олгох, тэдний үйл ажиллагааг зохицуулах тухай заасан болно.

137.3. Зэрэглэлтэй байх тухай шаардлага

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх нисгэгч нь:

(1) нислэг үйлдэх тухайн агаарын хөлгийн ангиллын хувьд ИНД-61 дүгээр хэсэгт заасны дагуу олгосон хүчин төгөлдөр ХАА-н зэрэглэлтэй байх,

(2) ХАА-н зориулалттай химийн бодис цацах бол ИНД-61-ийн дагуу олгогдох химийн зэрэглэлтэй байна.

(б) Дээрх (а) (1) хэсэг нь:

(1) ИНД-61 дүгээр хэсэгт заасан зэрэглэл бүхий Е ангиллын багш нисгэгчийн удирдлага дор ХАА-н зэрэглэлийн дадлага хийх,

(2) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр

(i) хөдөө аж ахуйн бараа материал тээвэрлэх, түгээх нислэг;

(ii) тариан талбай, ой мод, гол мөрөн дээгүүр 150 м (500 фут)-ээс доош

өндөрт үйлдэх нислэг;

(iii) мал, амьтан тээвэрлэх болон өвс тэжээл хаяж өгөх нислэгийн туршлагатай

тохиолдолуудад үл хамаарна.

137.5. Гэрчилгээтэй байх тухай шаардлага

Г Бүлэгт заасан удирдамж, заалтын дагуу ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээгүй аливаа этгээд арилжааны ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж үл болно.

137.7. Хассан

137.9. Осол, зөрчлийн талаар мэдээлэх

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхэлж буй аливаа этгээд осол, зөрчлийнхөө талаар ИНД-12-т заасны дагуу ИНЕГ-ын даргад мэдэгдэнэ.

Б БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ДҮРЭМ

137.51. Зорилго

Энэхүү дэд хэсэгт ИНД-91-т заасан ерөнхий үйл ажиллагаа, нислэгийн дүрэмд нэмэх дүрэм, уг дүрмийн хэрэгжилтэд үл хамаарах дүрмүүдийг тусгасан болно.

137.53. Цуцалсан

137.55. Аэродром дээр эргэх чиглэл

Энэхүү ХАА-н зориулалттай агаарын хөлгийн нислэг гүйцэтгэж буй, эсхүл дадлага хийж буй нисэгч нь:

- (1) зөвхөн ХАА-н зориулалттай агаарын хөлгийн нислэгт зориулан ашигладаг аэродром, эсхүл
- (2) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн нислэг үйлддэг болохыг заах газрын дохиоллыг ИНД-91-т зааварласаны дагуу тэмдэглэсэн аэродром

дээр

ИНД-91, ИНД-93-т тус тус зааснаас өөр чиглэлд газардах, хөөрөх үйлдлийг гүйцэтгэж болно.

137.57. Цуцалсан

137.59. Цуцалсан

137.61. Хүн амын төвлөрөл ихтэй нутаг дэвсгэр дээгүүрх нислэг

Хүн ам шигүү суурьшсан хот суурин газрын дээгүүр ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй нисгэгч нь:

- (1) Засгийн Газрын аливаа нэгжийн нэрийн өмнөөс нислэг үйлдэх бол,
- (2) ИНЕГ-ын даргын тодорхойлсон нөхцөл, хязгаарлалтын дагуу нислэг үйлдэх бол,
- (3) энэхүү ИНД-д заасны дагуу олгосон ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний дагуу олгосон эрх мэдлийн хүрээнд нислэг үйлдэх бол,
- (4) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь 137.205 дугаар дүрмийг биелүүлсэн бол ИНД-91-т зааснаас доогуур өндөрт нислэг үйлдэж болно.

137.63. Хүн амын төвлөрөлгүй нутаг дэвсгэр дээгүүрх нислэг

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх буюу дадлага хийж буй нисгэгч нь хүн амын сийрэг суурьшилтай хот суурин газрын дээгүүр нислэг үйлдэхдээ,

- (1) газрын гадаргуу дээр буй хүн, барилга байгууламжид ямарваа нэг аюул учруулахааргүй бол,
- (2) ойртох, эргэх, хөөрөхөд тухайн өндөр, орон зай шаардлагатай бол ИНД-91-т заасныг үл харгалзан аливаа саадаас ямар ч өндөр, орон зайд нисч болно.

137.65. Түлшний нөөц

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй буюу дадлага хийж буй нисгэгч нь,

(1) нисэх онгоцны хувьд 30 минутын,

(2) нисдэг тэрэгний хувьд урьдчилан тооцоолсон нислэгийн хугацаанаас 3 дахин урт хугацааны, эсхүл 30 минутын нислэгт хүрэлцэхүйц түлшний аль бага хэмжээтэйг нөөцөлсөн байна.

В БҮЛЭГ. ТУСГАЙ НИСЛЭГИЙН ДҮРЭМ

137.101. Зорилго

Энэхүү дэд хэсэгт Ж Бүлгийн 21 дүгээр хэсэгт заасны дагуу ХАА-н зориулалттай агаарын хөлгийн нислэг үйлдэх зорилгоор олгосон хязгаарлагдсан ангиллын нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ бүхий онгоцоор ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй буюу дадлага хийж буй нисгэгчид зориулсан ИНД-91-т тусгасан ерөнхий үйл ажиллагаа, нислэгийн дүрмийг мөрдөхгүй заалтуудыг тодорхойлсон болно.

137.103. Хөөрөх үеийн дээд жин

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй буюу дадлага хийж буй нисгэгчийн онгоц ИНД-91-т заасныг үл харгалзан, ингэхдээ (б) хэсэгт зааснаас хамааран тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсон жингээс илүү жинтэй тохиолдолд онгоцыг хөөрөхийг хориглоно. Ингэхдээ,

(1) нисгэгч Хавсралт Б-д жагсаасан журмыг биелүүлсэн,

(2) нисгэгч ачаагаа хаях арга хэмжээ авахад онгоц ачааны дээд жингийнхээ 80 хувиас багагүй хэмжээтэй ачааг 5 секундын дотор хаях төхөөрөмжөөр онгоцыг Г.5-д заасны дагуу тоногдсон бол хамаарахгүй.

(б) Хавсралт А-д тодорхойлсон гуравдагч талын эрсдэлтэй үед нисгэгч хөөрөх үеийн дээд жинг 137.107, 137.109-т тус тус заасны дагуу

тодорхойлно.

137.105. Гуравдагч талын эрсдэлгүй үед хөөрөх зай, нислэгийн зам

Хавсралт А-д тодорхойлсон гуравдагч талын эрсдэлгүй онгоцонд буй ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй буюу дадлага хийж буй нисгэгч нь

- (1) тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсон хөөрөх зай,
- (2) тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсон хөөрөх замын налууг мөрдөхгүй байж болно.

137.107. Гуравдагч талын эрсдэлтэй үед хөөрөх зай

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй буюу дадлага хийж буй нисгэгч нь онгоцонд Хавсралт А-д заасан гуравдагч талын эрсдэлтэй тохиолдолд (б) хэсэгт зааснаас хамааран, хөөрөх боломжит зай нь тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсон хөөрөх зайнаас 1.2 дахин илүү гэдгийг магадлана.

(б) Нисгэгч, хөөрөх зайг тооцоолохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- 1/ агаарын хөлгийн хөөрөхөөс өмнөх жин;
- 2/ аэродромын өндрийн даралт;
- 3/ аэродром дахь гадаа агаарын хэм;
- 4/ хөөрөх, буух зурвасны гадаргуугийн төрөл байдал;
- 5/ хөөрөх чиглэл дэх зурвасны налуу;
- 6/ угтах салхины, эгц урдаас чиглэсэн, бүрдэл хэсэг 50 хувиас ихгүй байх; эсхүл арын салхины, эгц араас чиглэсэн, бүрдэл хэсэг 150 хувиас багагүй байх.

137.109. Гуравдагч талын эрсдэлтэй үед хөөрөх нислэгийн зам

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй буюу

дадлага хийж буй нисгэгч нь Хавсралт А-д заасан гуравдагч талын эрсдэлтэй тохиолдолд (б)-д зааснаас хамааран, хөөрөх зам нь:

- 1/ 150 метр (500 фут) дээр нэмэх $0.025D$ -гээс багагүй босоо зайд,
- 2/ 30 м дээр нэмэх $0.1D$ -гээс багагүй хажуугийн зайд аливаа саадгүй гэдгийг магадлана.

“D”- хөөрөх боломжит зайн төгсгөлөөс агаарын хөлгийн нисэн өнгөрүүлсэн замыг хэвтээ тэнхлэгт буулгасан урт.

(б) Нисгэгч нь энэ зүйлийн (а)-д заасан зайг тооцоолохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

- 1/ хөөрөх зам нь 137.207-д заагдсан хөөрөх зайн төгсгөл дээрх хөөрөх гадаргуугаас дээш 15 метр (50 фут)-ийн өндрөөс эхэлж 150 метр (500 фут)-ийн өндөрт төгсөнө;
- 2/ агаарын хөлгийг 20 градусаас дээш өнцгөөр хазайлгаж болохгүй;
- 3/ нислэгийн төлөвлөсөн замаас хажуу тийш 150 м-ээс цааш саадыг тооцоогүй байх боломжтой.

Г БҮЛЭГ. АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

137.151. Гэрчилгээ авах өргөдөл гаргах

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь ИНЕГ-24137/01 маягтыг бөглөж, **Акт**-д заасан журмын дагуу холбогдох өргөдлийн хураамжийг төлсөн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

137.153. Гэрчилгээ олгох

Иргэний Нисэхийн Хуулийн 8 дугаар хэсэгт зааснаас хамааран дараах шаардлагыг хангасан гэж ИНЕГ-ын дарга тооцсон тохиолдолд өргөдөл гаргагч нь ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагааны гэрчилгээ авах эрхтэй. Үүнд:

- (1) өргөдөл гаргагчийн зүгээс явуулах бүх үйл ажиллагаа энэхүү

дүрэмд заасны дагуу явагдаж, санхүүжиж байгааг батлан хариуцах эрх бүхий удирдах ажилтаныг Гүйцэтгэх Захиралаар томилсон байх,
(2) удирдах ажилтаныг ерөнхий нисгэгчээр томилсон байх ба уг ерөнхий нисгэгч нь:

(i) ИНД-61-ийн дагуу олгогдсон ХАА-н 1-р ангилалтай буюу ангилалтай байсан,

(ii) ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц туршлагатай, үйлдэх нислэгтээ

харгалзах зэрэглэлтэй байна.

(3) өргөдөл гаргагч болон (1), (2) дугаар хэсэгт дурьдсан удирдах ажилтан(ууд) нь ёс суртахууны доголдолгүй байна.

(4) гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлах аливаа нөхцөл байдал үгүй байх.

137.155. Цуцалсан

137.157. Гэрчилгээний хүчинтэй хугацаа

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээг 5 хүртэлх жилийн хугацаагаар олгох буюу сунгаж болно.

(б) ХАА-н зориулалттай гэрчилгээ нь хугацаа дууссан, түр түдгэлзүүлсэн, цуцалсанаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна.

(в) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний хугацаа дууссан, түр түдгэлзүүлсэн, цуцалсан даруйд ИНЕГ-ын даргад хураалгана.

(г) Түр түдгэлзүүлсэн ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшгч нь гэрчилгээний талаарх зохих мэдээллийг ИНЕГ-ын даргад нэн даруй өгнө.

137.159. Гэрчилгээний хугацааг сунгах

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний хугацаа сунгуулах тухай өргөдлийг ИНЕГ-24137/01 маягтын дагуу гаргана.

(б) Уг өргөдөлийг гэрчилгээн дээр буй сунгуулах огнооноос өмнө, хэрэв тусгайлан огноо заагаагүй бол уг гэрчилгээний хугацаа дуусахаас 60-аас цөөнгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлсэн байна.

137.161. Цуцалсан

Д БҮЛЭГ. АРИЛЖААНЫ НИСЛЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА

137.201. Бүртгэл тэмдэглэл

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлүүдийг агуулсан үнэн зөв тэмдэглэсэн бүртгэлийг үйл ажиллагааны үндсэн байршилдаа хадгална. Үүнд:

(1) үйлчлүүлэгч (захиалагч) тус бүрийн нэр хаяг;

(2) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн нислэг бүрийн огноо;

(3) ХАА-н зориулалттай гаарын хөлөг бүрийн зөөвөрлөж, түгээсэн материалын нэр,

тоо хэмжээ;

(4) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж байгаа нисгэгч бүрийн

нэр, хаяг, нислэгийн багийн зөвшөөрлийн дугаар, **мэргэжлийн үнэмлэх,**

зэрэглэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

(5) нисгэгч тус бүрийн ХАА-н зэрэглэл авсан огноо, эсвэл ИНД-61-т заасан жил

бүрийн ур чадварын шалгалтаа амжилттай өгч дууссан огнооны аль сүүлд

бүртгүүлсэн огноог;

(6) нисгэгч бүрийн ХАА-н химийн зэрэглэл авсан огноо, эсвэл ИНД-61-т заасан

давтан сэргээх дадлага хийж амжилттай дуусгасан огнооны аль сүүлд

бүртгүүлсэн огноо.

(б) Дээрх бүртгэл, тэмдэглэлүүдийг нислэгийн үйл ажиллагаа дууссанаас хойш 2 жилээс доошгүй хугацаагаар хадгална.

137.203. Үндсэн бус баазаас нислэг үйлдэх

Үйл ажиллагааны үндсэн бус баазаас дараалсан 14 хоног буюу түүнээс дээш хугацаагаар арилжааны ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлддэг ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь тухайн баазад нисгэгч томилно. Томилогдсон нисгэгч нь:

- (1) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэх эрхтэй, ХАА-н химийн зэрэглэлтэй байна;
- (2) үндсэн бус баазаас үйлдэх нислэгийн үйл ажиллагааг хариуцна;
- (3) тухайн газарт гүйцэтгэх ажил үүргийг зохион байгуулах, бүртгэл мэдээ хөтлөх хариуцлага хүлээнэ.

137.205. Хүн амын төвлөрөл ихтэй нутаг дэвсгэр дээгүүрх нислэг

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх эрчилгээ эзэмшигч нь ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр хүн ам шигүү суурьшсан хот суурин дээгүүр нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх тохиолдолд:

- (1) уг нислэгийн талаар тус үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс болон байгууллага тус бүрт зориулсан товч мэдээлэл, нислэгийн төлөвлөгөөг хавсаргах,
- (2) энэ хэсгийн (а) (1)-т заасны дагуу уг нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс, байгууллага бүрт төлөвлөгөөний дагуу товч мэдээлэл өгөх,
- (3) үйл ажиллагааны талаарх мэдээллийг үр дүнтэй арга хэрэгсэл

ашиглан олон нийтэд хүргэнэ.

(б) Энэ хэсгийн (а) (1)-т дурьдсан төлөвлөгөөнд дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

(1) нислэгийн үед гарч болзошгүй саад,

(2) ашиглаж буй агаарын хөлөг нислэгийн онцгой тохиолдлын үед буух хүчин чадлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл,

(3) шаардлагатай тохиолдолд нислэгийн хөдөлгөөнийг хянах үйлчилгээний байгууллагатай хийх зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

(в) Хүн ам шигүү суурьшсан хот суурингийн дээгүүр ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн 1 дүгээр нисгэгч нь (а) (1)-т дурьдсан төлөвлөгөөг биелүүлнэ.

(г) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь (а) (1)-т заасан төлөвлөөг тухайн нислэгийн үйл ажиллагаа дууссанаас хойш хамгийн багадаа 2 жилийн хугацаанд хадгална.

137.207. Боловсон хүчний хангалт

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь 137.53(1)-т заасан удирдах албан тушаалтныг гэрээгээр болон хөлсөөр үргэлжлүүлэн ажиллуулна.

137.209. Үйл ажиллагааны өөрчлөлт

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигч нь:

(1) ИНЕГ-ын 24137/01 маягтад шаардагдах мэдээлэлд нөлөөлөх аливаа өөрчлөлтийн талаар ИНЕГ-ын даргад бичгээр мэдэгдэнэ.

(2) Гүйцэтгэх Захирал болон ерөнхий нисгэгчээ өөрчлөхөөсөө өмнө ИНЕГ-ын даргад мэдэгдэж зөвшөөрөл авна.

137.211 Цуцалсан

Е БҮЛЭГ. ХЭРЭГСЭЛ БА ТОНОГЛОЛ

137.251. Зорилго

Энэхүү дэд хэсэгт энэ Бүлгийн дүрмийн дагуу үйлдэх ХАА-н зориулалттай агаарын хөлгийн нислэгт ашиглах агаарын хөлөгт ИНД-91-ийн дагуу тавигдах шаардлагууд дээр хэрэгсэл, тоноглолыг тодорхойлно.

137.253. Ерөнхий зүйл

Аливаа этгээд дараах тохиолдолд ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эхэлж үл болно. Үүнд:

- (1) агаарын хөлөг нь шаардлагатай ангилал, тоо ширхэг бүхий тоноглол, хэрэгслээр энэхүү дэд бүлэг болон ИНД-91-т заасны дагуу тоноглогдоогүй бол;
- (2) агаарын хөлөгт суурилагдсан тоноглол, хэрэгсэл нь дор жагсаасан тохирох тодорхойлолт, нислэгт тэнцэх чанарын загвар, стандартад тохирохгүй бол:
 - (i) энэ дүрмийн Хавсралт Г,
 - (ii) ИНД-21-ийн Хавсралт В,
 - (iii) ИНД-26,
 - (iv) ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт, стандартын хувилбар.
- (3) тоноглол, хэрэгсэл нь тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан заавар, эсхүл ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн зааврын дагуу суурилагдаагүй бол;
- (4) тухайн агаарын хөлөгт ашиглагдах, ИНД-91-ийн дагуу батлагдсан Нислэгт зөвшөөрөгдөх хамгийн цөөн тоноглолын жагсаалтад тусгагдсан тоноглол, хэрэгсэл ажиллагаагүй бол.

137.255. Суудал ба бэхэлгээ

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгийн нисэх багийн гишүүдийн суудлыг мөрөвчит даруулга бүсээр

тоноглосон байна.

137.257. Нэмэлт хэрэгсэл

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлөгт **халтиралгаа заагч** (slip indicator) хэрэглэл суурилуулсан байна.


137.259. Нэмэлт тоноглол

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлөг бүрийг дараах тоноглолоор тоноглосон байна. Үүнд:

- (1) батлагдсан шүршигч сав, эсвэл бункер савны аль тохирохыг;
- (2) бункер саван дахь бодисын дээд түвшинг нисгэгчид заан харуулах төхөөрөмж;
- (3) агаарын хөлгийн ачаагаа хаях төхөөрөмжийг дотор шүршигч/бункер савны хамтаар суурилуулсан;
- (4) Хавсралт Г-д заасан
 - (i) бункер/шүршигч савны бүтцийн хамгийн их ачаалал;
 - (ii) зорчигчдын байрлал;
 - (iii) нислэгийн хязгаарлалт;
 - (iv) ачаагаа хаях төхөөрөмжийн хүчин чадал зэргийг харуулсан зурагт хуудас.

ХАВСРАЛТ А. ГУРАВДАГЧ ТАЛЫН ЭРСДЭЛ

Зураг 1-т үзүүлсэн хөөрөх талбайд гуравдагч талын өмч, эсхүл гуравдагч тал өөрөө байгаа үед гуравдагч талын эрсдэл үүснэ.




Зураг 1

ХАВСРАЛТ Б. ЖИНГИЙН ХЭТРЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ

(а) 137.103 (а)-д зөвшөөрсөн, нисгэгчийн гүйцэтгэх журам дараах зүйлүүдээс тогтоно. Үүнд:

- (1) агаарын хөлгийн Нислэгийн ашиглалтын заавраас хөөрөх дээд жин болон агаарын хөлгийн даацын хязгаарыг олсон байх;
- (2) зураг 2-т үзүүлсэн графикийн хөндлөн тэнхлэг дээр онгоцны ачааллын хязгаарыг олоод, дээш босоогоор явуулж стандарт шугамтай огтлолцсон цэгээс босоо тэнхлэг дээрх хамаарал, жинг нэмэгдүүлж болох хамгийн их утгыг хувь (%) - иар олох;
- (3) дээрх нэмэгдэл утгыг нэмж хөөрөх дээд жинг шинээр тодорхойлох;



Онгоцны даацын хязгаарын өсөлт

Зураг 2

(б) Шинээр тодорхойлсон хөөрөх дээд жинтэй нислэг үйлдэхдээ нисгэгч дараах хүчин зүйлүүдийг тооцсон байна. Үүнд:

- (1) тухайн аэродромын өндрийн даралт;
- (2) гаднах агаарын хэм;
- (3) хөөрөх, буух зурвасны гадаргуугийн төрөл байдал;
- (4) хөөрөх чиглэл дэх зурвасны налуу;
- (5) хөөрөх чиглэл дэх угтах болон арын салхи;
- (б) нислэгт нөлөөлж болох бусад хүчин зүйлүүд.

ХАВСРАЛТ В. Цуцалсан

ХАВСРАЛТ Г. ХЭРЭГЛЭЛ ТОНОГЛОЛЫН НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАНАР

Дэд бүлэг Е-д заасан хэрэглэл, тоноглол нь дараах тодорхойлолт болон шаардлагуудыг хангасан байна.

Г.1. Суудал болон бэхэлгээ

Суудал болон аюулгүйн даруулга бүс нь урагш үүсэх 12 гр инерцийн хүчийг тэсвэрлэхүйц хийцтэй байна.

Г.2. Цуцалсан

Г.3. Бункер болон шүршигч сав

(а) Ослын үед бункер болон шүршигч сав, түүний суурь бэхэлгээ нь онгоцонд буй аливаа этгээдийг гэмтээхээргүй байрлалд, урагш үүсэх 12 гр инерцийн хүчийг тэсвэрлэхүйц хийцтэй байна.

(б) нисэх багийн өмнө байрлуулсан бункер/шүршигч савны суурь бэхэлгээний бүтэц дараах инерцийн хүчнүүдийг тэсвэрлэхүйц байна.

(1) арын 1.5 гр

(2) хажуугийн 1.0 гр

(в) Энэ хэсгийн (а) ба (б)-д заасныг баталгаажуулахын тулд бункер/шүршигч савыг холбогдох Нислэгийн ашиглалтын зааврын хязгаарлалтанд заасан хамгийн их ачааллаар дүүргэсэн байхаар тооцно.

Г.4. Бункерийн багтаамжийн дээд түвшин

Нисгэгч нь бункерийн багтаамжийн дээд түвшинг тодорхойлохдоо заалтаар, эсхүл нүдээр харж, холбогдох Нислэгийн ашиглалтын зааварт тодорхойлсон хамгийн их ачааллын хагасаас илүү ачааллын хувьд, ХАА-н материалын нягтралтай хамааралтайгаар зөвшөөрөгдсөн түвшинд байхаар тооцоолно.

Г.5. Ачаа хаях тоноглол

(а) Ачаа хаях тоноглол нь:

- (1) ажиллуулахад хялбар байх ба
- (2) нисгэгч нь ачаа хаях удирдлагыг байнга барьж байхааргүй, зөвхөн нэг удаагийн үйлдлээр бүрэн гүйцэд хаяхаар хийгдсэн байна.

(б) Ачаа хаях тоноглолын хүчин чадалыг

- (1) Шалгах нислэгийн үед ачаа хаях хүчин чадлыг шалгаж үзэх бөгөөд

- (i) ачих бордооны зөвшөөрөгдсөн дээд хэмжээ нь Нислэгийн ашиглалтын зааварт заасан байна,
- (ii) тусгай үүрэг бүхий төхөөрөмжийг суурилуулах бол уг төхөөрөмжийг суурилуулсаны дараа түгээмэл хэрэглэгддэг ХАА-н материалыг зөвшөөрөгдсөн дээд хэмжээгээр ачина.

- (2) тухайн онгоцны Нислэгийн гарын авлагад заасан байна.

Г.6 Тэмдэг тэмдэглэгээ, зурагт хуудас

Г.6.1. Ерөнхий зүйл.

(а) Тэмдэг, тэмдэглэгээ, зурагт хуудсыг нүдэнд үзэгдэхүйц газарт, арилахааргүй, сүүдэрлэгдэхээргүй, хуурч унахааргүй байрлуулсан байна.

(б) Тэмдэг, тэмдэглэгээ, зурагт хуудсанд ашигласан нэгжүүд нь холбогдох багаж хэрэгсэл, эсхүл холбогдох Нислэгийн ашиглалтын зааварт заасантай адил байна.

Г.6.2. Бункер болон шүршигч савны хамгийн их ачаалал

Бункер болон шүршигч савны хамгийн их ачааллыг заасан зурагт хуудсыг

- (1) байрлуулахдаа

- (i) бункер/шүршигч савны цэнэглэх цоргоны ойролцоо
- (ii) бүрэн харагдахуйцаар тогтооно.

- (2) бункерт зөвшөөрөгдсөн хамгийн их ачааллыг хэтрүүлж болохгүйг заасан байна.

Г.6.3. Ачаа хаях тоноглолын хүчин чадал

ИНД-137.259(3)-т заасны дагуу ачаа хаях тоноглол бүхий ХАА-н зориулалттай онгоцууд нь агаарын хөлгийн бүхээгт, нисгэгчид харагдахуйц газар дараахыг бичиж байрлуулна.

АНХААРУУЛГА

Энэхүү онгоцны ачаа хаях хүчин чадал нь онгоцны тохиргоо, хаях материалын төрөл, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болно.

Г.6.4. Зорчигчийн байрлал

Зорчигчдын байрлал агаарын хөлгийн гадна талаас харагдахгүй тохиолдолд агаарын хөлгийн их биений гадна, хоёр талд, зорчигчийн байрлалын ойролцоо Зураг 3-т үзүүлсэн диаграммыг тэмдэглэсэн байна.



Цагаан дэвсгэр дээр улаан гурвалжин дотор хар дүрсийг байршуулна.

Зураг 3

Г.6.5. Онгоцны нислэгийн хязгаарлалтууд

(а) ХАА-н зориулалттай агаарын хөлгийн бүхээгт, нисгэгчид харагдахуйц газар дараах зүйлсийг хамтад нь буюу салангид бичиж байрлуулна.

АНХААР

Энэхүү онгоцоор зөвшөөрөгдсөн дээд жинг хэтрүүлэх нь ашиглаж буй тохиргоондоо 5 секундын дотор багтаан зөвшөөрөгдсөн дээд хэмжээний 80 хувиас доошгүй хэмжээтэй ачааг хаях тоноглолыг хамгийн бага хүчин чадалд хүргэнэ.

АНХААРУУЛГА

ХАА-н зориулалттай агаарын хөлгөөр уран жолоодлого үйлдэхийг хориглоно. Нислэгийн огцом жолоодлогоос зайлсхий.

(б) ИНД-137.Г.65-д буй “Анхаар” тэмдэглэгээ 2016 оны 2 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжих бөгөөд Г.65(а)-д заасны дагуу АНХААР тэмдэглэгээг үргэлжлүүлэн хэрэглэж болно.